



**CEC Investment**  
СИ-И-СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК

# Жилийн тайлан 2025

---

Бидэнтэй холбогдох:  
Утас: (976) 7575-5511  
Имэйл: [cesci@irc.mn](mailto:cesci@irc.mn)  
Сайт: [www.cesci.mn](http://www.cesci.mn)

---

Хаяг:  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
Олимпийн гудамж, “Нью горизонтс” оффис,  
702 тоот

# Агуулга

## 01 Удиртгал

Бидний тухай  
ТУЗ-ийн даргын мэндчилгээ  
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

## 02 Компанийн засаглал

Компанийн засаглал  
ТУЗ болон Удирдлагын бүрэлдэхүүн  
Компанийн бүтэц  
Хүний нөөц

## 03 2025 оны онцлох үйл явдлууд

Дижитал шилжилтийн стратеги ба түншлэл  
Дэлхийн мөнгөний 7 хоног аян  
Цахим сувгууд нэмэгдлээ  
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас  
Бизнесээ томруулья чуулган  
ТОС холбоонд гишүүнээр элслээ  
WeCode амлалт  
ISO/EIC 27001 нэвтрүүлээ  
Нийт хөрөнгөө нэмэгдүүлэв  
Онцлох төсөл, хөтөлбөрүүд

## 04 Тогтвортой хөгжлийн бодлого

Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги  
Тогтвортой хөгжилд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалт  
Харилцагчдад олгосон санхүүжилтүүд  
Нөлөө

## 05 Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлагын бодлого  
Зээлийн эрсдэлийн удирдлага  
Үйл ажиллагааны эрсдэлийн  
Мэдээллийн аюулгүй байдал  
Санхүүгийн эрсдэл  
Зах зээлийн эрсдэл  
Комплайнсын эрсдэл  
Нэр хүндийн эрсдэл  
Стратегийн эрсдэл  
Хөрвөх чадварын эрсдэл

# Агуулга

---

## 06 Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний стандарт  
Цахим суваг, дижитал шийдэл, биет салбар  
Сэтгэл ханамж, санал гомдол, талархал

# УДИРТГАЛ

---

# БИДНИЙ ТУХАЙ

“Си И Си Инвестмент ББСБ” нь 2013 оны 11-р сарын 06-ны өдөр Монголын банк санхүүгийн салбарт зээл, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэйгөөр “Юнайтэд Прожекст Корпорэйшн” ХХК ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.

2022 оноос үйл ажиллагаагаа эрчимжүүлэн зах зээлд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд санал болгож, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр одоогийн байдлаар өөрийн 3 биет салбар, хамтрагч байгууллагын 4 цахим сувагтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2025 онд нийт 24 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр амжилттай ажилласан бөгөөд нийт хөрөнгийн дүн өмнөх онтой харьцуулахад 2.1 дахин нэмэгдлээ.

## Эрхэм зорилго

Шинэ жишиг тогтооно

## Алсын хараа

Хүмүүн чадамжийг технологийн хөгжилтэй уялдуулан ухаалаг хөрөнгө оруулагч болно.

## Үнэт зүйлс

### Өөриймсөг

Бид компанийн гаргасан амжилт миний амжилт гэдэгт итгэдэг.

### Хариуцлагатай

Бид миний ажлаас бусдын болон компанийн амжилт хамаарна гэдэгт итгэдэг.

### Эерэг хандлагатай

Бид бусдын ажил бүтвэл өөрийн ажил бүтнэ гэдэгт итгэдэг.

### Үнэнч, шударга

Бид хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж, ёс зүйтэйгээр хамтран ажилладаг гэдэгт итгэдэг.

### Манлайлагч

Бид зорьсондоо хүрэхэд баг хамт олон төдийгүй хувь хүн бүрийн манлайлал, идэвх зүтгэл, оролцоо чухал гэдэгт итгэдэг.

### Хөрвөх чадвартай

Бид ямар ч өөрчлөлтөд бэлэн гэдэгтээ итгэдэг.

### EQ

Бид өөрийгөө ойлгон, сэтгэл хөдлөлөө удирдаж, өөрийгөө идэвхжүүлэн, өөрийгөө бусдын оронд тавьж, зөв харилцаа үүсгэж чаддаг гэдэгтээ итгэдэг.

### Мэргэшсэн

Бид тасралтгүй суралцаж мэргэжил, чадавхиа сайжруулан бусдыг хөгжүүлснээр амжилтад хүрнэ гэдэгт итгэдэг.

### Багаар ажиллах чадвартай

Бид эерэг уур амьсгал, тав тухтай орчныг бүрдүүлж, харилцан итгэлцлийг бий болгосноор хүчирхэг хамт олон болно гэдэгт итгэдэг.

### Шинийг санаачлагч

Бид цаг үетэйгээ хөл нийлүүлэн шинэ санал санаачилгыг дэмжин бүтээлчээр ажилладаг гэдэгтээ итгэдэг.

# ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Бидний бизнесийн үйл ажиллагаа нь нийгэм, эдийн засагт бодитой эерэг нөлөө үзүүлэхүйц, тогтвортой хөгжилд чиглэсэн байхыг ямагт эрмэлзэж ажиллаж ирсэн. Манай байгууллагын хувьд 2025 он нь засаглалын шинэчлэл, тогтвортой хөгжлийн суурийг бататгасан онцлох жил байлаа. Амжилтын гол үндэс болсон баг хамт олноо мэргэжлийн өндөр ур чадвартай, залуу, эрч хүчтэй хүний нөөцөөр бүрдүүлэн хурдтай, өсөлт өндөртэй, амжилттай ажилласаар байна.

Тайлант онд ТУЗ-ийн шийдвэр гаргалт, ажилтнуудыг хөгжүүлж, гишүүдийн бие даасан байдал хараат бус байдлыг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн өндөр мэдлэг, туршлагатай хараат бус гишүүнийг бүрэлдэхүүндээ нэмж, стратегийн хяналт, удирдлагыг илүү бэхжүүллээ. Мөн ТУЗ-ын дэргэдэх хороод эрчимтэй ажиллаж бидний гол үнэт зүйлс болох хүний нөөцийг дэмжих, цалин урамшууллын тогтолцоог сайжруулах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, зээлийн чанарыг сайжруулах зэрэг бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан.

Түүнчлэн бид Тогтвортой хөгжлийн бодлогоо баталж, байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмыг байгууллагын стратеги, өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх урт хугацаанд тогтвортой, хариуцлагатай өсөлтийг ханган ажиллах суурийг тавилаа. Энэ нь нийгэм, хүрээлэн буй орчны өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарласан, ирээдүйд чиглэсэн хөгжлийг дэмжих, санхүүжилт олгох чухал ач холбогдолтой алхам билээ.

## **Х. Гиймаа**

ТУЗ-ийн дарга

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Манай санхүүгийн байгууллагад итгэл хүлээлгэн харилцдаг харилцагч, хамтран ажиллагч, хөрөнгө оруулагч та бүхэнд мэндчилж байна. “Шинэ жишиг тогтооно” эрхэм зорилгод нэгдсэн манай хамт олон санхүүгийн байгууллагын хувьд харилцагч, хамтран ажиллагч, хөрөнгө оруулагч нартаа чанартай өсөлт, мэргэжлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, өндөр үр шимийг хүртээхээр зорьж, хууль дүрмийг чандлан мөрдөж ажиллаж байна.

Бид 2025 онд бизнесийн стратеги, технологийн туршлагатай зөвлөх Арвинд Жошитой хамтран ажиллаж, байгууллагынхаа дунд хугацааны стратеги зорилгуудаа тодорхойлсон нь онцлох үр дүнтэй үйл явдал болсон бөгөөд бизнесийн тэлэлт, туршлагаа нэмэх, олон улсын стандартад нийцэх, дижитал шилжилтээ эрчимжүүлэх үндсэн зорилгуудад төвлөрч ажилласан. Үүний үр дүнд нийт хөрөнгийн хэмжээгээ 2.1 дахин нэмэгдүүлж, цахим сувгуудаа тэлж, хүртээмжийг нэмэгдүүлэн харилцагчийн тоо 2.2 дахин өсөж, 27'335 харилцагчтай боллоо. Харилцагч, хамтрагч байгууллагад итгэлтэй, найдвартай үйлчилгээг хүргэж, үйл ажиллагаагаа Мэдээллийн аюулгүй байдлын MNS ISO/IEC 27001:2023 стандартад нийцүүлэн, стандартын баталгаажуулалтаа авлаа.

Мөн ТУЗ-ийн манлайлал, дэмжлэгтэйгээр бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлэх ажлыг эхлүүлэн ToC холбоонд үндсэн гишүүнээр нэгдэж, Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгээ баталж, харилцагчдад ногоон зээлийн бүтээгдэхүүнээ олгож эхэлсэн.

Энэхүү жилийн тайлан нь харилцагч, хамтрагч байгууллагууд, зохицуулагч байгууллага болон хөрөнгө оруулагчдад бизнесээ тайлагнах, ил тод байдлыг хангах, харилцан үр дүнтэй хамтралыг бий болгоход ихээхэн хувь нэмэр болно гэж итгэж байна.

## **Б.Азжаргал**

Гүйцэтгэх захирал

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

---

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь Монгол улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрээр байгуулагдсан ББСБ бөгөөд Монгол улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох дүрэм, журам, Компанийн засаглалын кодексийг мөрдөн ажилладаг.

Бид зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар Хувьцаа эзэмшигчид, ТУЗ, Удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондох харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор байна.

“Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ийн зүгээс хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал, хагас жил, жилийн эцсийн хугацааг хамруулан мэдээлэх, ил тод байдлыг хангах стратегийг баримтлан тухай бүр тайлан бэлтгэж олон нийтэд хүргэх зорилгоор өөрийн цахим хуудаст тогтмол байршуулдаг.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлснээр бизнес, засаглал, байгаль орчин, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгоход анхаарч ажиллаж байна.

Түүнчлэн, Компанийн ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хагас жил, жилийн эцэст өөрийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд нээлттэй хүргэж байна.

## **“Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилт, түүний үнэлгээ**

СЗХ-ны 2025 оны “Компанийн засаглалын кодексийн үнэлгээ”-ээр “Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь 90.3% хувийн үнэлгээгээр сайн, хэвийн гэж үнэлэгдсэн.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Х.Гиймаа**

ТУЗ-ийн дарга  
МУ-ын Аж үйлдвэрийн  
гавьяат ажилтан



**Ц.Ууганбаяр**

ТУЗ-ийн гишүүн  
Юнайтэд  
корпорэйшн  
Гүйцэтгэх захирал  
прожектс  
ХХК-ийн



**Н.Урантуяа**

ТУЗ-ийн гишүүн  
Юнайтэд  
Корпорэйшн  
Санхүү хариуцсан захирал  
Прожектс  
ХХК-ийн



**П.Ундрах-Эрдэнэ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Өмгөөллийн Цэц Мэргэн ХХН  
Гүйцэтгэх захирал



**Б.Баярмаа**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Тэрбум мод сангийн  
Гүйцэтгэх захирал

# УДИРДЛАГЫН БАГ



**Б.Азжаргал**

Гүйцэтгэх захирал  
Ажлын туршлага 15 жил



**А.Гэрэлт-Од**

Үйл ажиллагаа хариуцсан  
дэд захирал  
Ажлын туршлага 16 жил



**П.Ганзориг**

Комплайнс хариуцсан менежер  
Ажлын туршлага 22 жил



**Д.Мөнх-Очир**

Хөрөнгө оруулалтын менежер  
Ажлын туршлага 8 жил



**Ж.Арвинд**

Дижитал шилжилт,  
технологи хариуцсан  
зөвлөх  
Ажлын туршлага 30 жил

# КОМПАНИЙН БҮТЭЦ



### ТУЗ-ийн үйл ажиллагааны тойм

Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 5 гишүүнтэй, үүнээс Хараат бус гишүүн 2, нийт гишүүдийн 40% нь хараат бус гишүүдээс бүрдэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны Засаглалын кодекст нийцүүлж, дараах чиглэлээр шийдвэрүүдийг гарган ажиллав.

1. Компанийн 2024 оны төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл
2. Компанийн 2025 оны төлөвлөгөө, төсөв батлах тухай
3. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг үйл ажиллагааны журам шинэчлэн батлах тухай
4. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг гишүүд шинэчлэн батлах тухай
5. Компанийн бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлах тухай
6. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилттэй холбоотой дүрэм, журам шинээр батлах тухай

### ТУЗ-ын хуралдааны тойм

	Цахим	Биет	Нийт хурлын тоо	Тогтоол, шийдвэр
Төлөөлөн удирдах зөвлөл	32	4	36	36
Аудитын хороо	3	-	3	5
Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо	1	1	2	6
Эрсдэлийн удирдлагын хороо	1	-	1	3

### Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо

Тайлант 2025 онд Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь компанийн засаглалын тасралтгүй байдлыг хангах, удирдлагын түвшний цалин урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, гишүүдийг томилох чиглэлээр дараах үндсэн ажлуудыг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох асуудлыг шийдвэрлэх
- Гүйцэтгэх захирлын урамшууллын гэрээний нөхцөл, холбогдох зохицуулалтын талаар хэлэлцэх
- Шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, хөлсний нөхцөлийн талаар хэлэлцэж шийдвэрлэх
- Компанийн үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцүүлэн Зээлийн хороог байгуулах, гишүүдийг томилох асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.

Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг Гүйцэтгэх захирлын бизнес төлөвлөгөөнд тусгасан зорилтуудын биелэлтээр ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин урамшууллыг олгох бөгөөд үүнд санхүүгийн тоон зорилтуудын биелэлт, зах зээл, бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчийн үйлчилгээний зорилтуудын биелэлт, дотоод процессын сайжруулалт, бизнес хөгжлийн үйл ажиллагааны зорилтуудын биелэлт, хүний нөөц, бүтээмжтэй холбоотой зорилтуудын биелэлт зэрэг 4 үндсэн бүлэг үзүүлэлтүүдийг багтаана.

# ХҮНИЙ НӨӨЦ

Манай байгууллага нь тогтвортой өсөлттэй, санхүүгийн салбарт эрч хүчтэй ажиллаж буй залуу хамт олон юм. Бид ажилтнуудынхаа карьерын өсөлт, хөгжилд бодит боломжийг бүрдүүлж, тасралтгүй суралцах орчин, оролцоог дэмжин, ажил амьдралын тэнцвэрийг хангасан бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Дундаж нас

**32**


Санхүүгийн салбарт  
ажилласан дундаж жил

**5.26**

Үе хоорондын ялгаа



Хүйсийн харьцаа



## Сургалт ба хөгжил

Бид ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд онцгой анхаардаг.

- **Skillathon хөтөлбөр:** “Юнайтэд Прожекст Корпорэйшн” группийн хэмжээнд зохион байгуулагдсан тус хөтөлбөрийн хүрээнд 9 удаагийн нийт 27 цагийн цогц сургалтыг амжилттай хэрэгжүүллээ.
- **Ур чадварын үнэлгээ:** 2025 оноос ажилтнуудын ур чадварыг Олон улсын жишигт нийцсэн аргачлалаар үнэлж эхэлсэн. Энэхүү үнэлгээний үр дүнд ажилтнуудын дараагийн түвшинд хүрэхэд шаардлагатай ур чадварыг тодорхойлж, илүү оновчтой хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.
- **70:20:10 хөгжлийн аргачлал:** Ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 70:20:10 хөгжлийн зарчмыг хэрэгжүүлж байна. Үүнд:
  - 70%** - ажлын байран дээрх бодит туршлага, төсөл, үүрэг даалгавраар дамжуулан суралцах
  - 20%** - хамтран ажиллах, зөвлөх, коучинг, туршлага солилцох замаар хөгжих
  - 10%** - байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу албан ёсны сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдэд хамрагдах

## Карьер хөгжил

Бид дотоод нөөцөд тулгуурласан өсөлтийг дэмжиж, шаардлагатай албан тушаалуудад залгамж халааг системтэйгээр бэлтгэдэг. Ажилтнууд өөрсдийн карьерын замналыг тодорхой харж, шат дараатай өсөх боломжтой тодорхой шаардлага, шатлал, үнэлгээний шалгуур бүхий ил тод тогтолцоотой бөгөөд ажилтнуудын ур чадвар, гүйцэтгэлд үндэслэн дотоод дэвшил олгох, удирдах түвшний ажилтнуудыг бэлтгэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээ.

## Хэвтээ шилжилт

Ажилтнууд албан тушаалын хувьд шатлал ахиж дэвшихээс гадна өөр өөр чиг үүрэг, баг, нэгжүүдэд шилжин ажиллах боломжтой. Энэ нь олон талт ур чадвар эзэмших, байгууллагын үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд ойлгох, цаашдын карьер өсөлтөд бэлтгэгдэх давуу талыг бий болголоо.

## Оролцоо, шийдвэр гаргалт

Бид шийдвэр гаргалтад ажилтнуудын оролцоог хангахыг зорьдог бөгөөд тодорхой түвшний асуудлуудад хамтын шийдвэр гаргах зарчмыг (Decision-making matrix) ашиглан ил тод хариуцлагатай байдлыг бий болгосон. Мөн ажилтнуудын санал санаачилгыг дэмжих нээлттэй соёлыг төлөвшүүлж, шинэлэг бүтээлч шийдлүүд, сайжруулалтын саналын систем, хэрэгжүүлж, үр дүнг нь урамшуулалтай холбон дэмждэг.

Манай байгууллага шат дамжлага багатай, уян хатан удирдлагын бүтэцтэй. Ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа өөрсдийн шууд удирдлагуудтай нягт хамтран ажилладаг. Компанийн томоохон шийдвэр гаргалтыг 2025 оноос эхлэн удирдлагын хороо байгуулан хэлэлцэж, шийдвэрлэж байна.

## Эрүүл мэнд ба нийгмийн оролцоо

"Эрүүл ажилтан – Амжилтын үндэс" зарчмын хүрээнд:

- Урьдчилан сэргийлэх үзлэг: Жил бүр нийт ажилтнуудыг иж бүрэн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулдаг.
- GYMНUB төсөл: Эрүүл, зөв амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор GYMНUB төсөлд нэгдэж, 14 ажилтанд фитнес төвд хичээллэх боломжийг олгосон бөгөөд спорт заал, фитнесийн хөнгөлөлтийг тогтмол хэрэгжүүлж байна.
- Нийгмийн хариуцлага: Манай ажилтнууд нийгмийн сайн сайхны төлөө идэвхтэй оролцдог бөгөөд 2025 онд цусаа хандивлаж, хүмүүнлэгийн үйлсэд хувь нэмрээ орууллаа.

## Ажлын таатай орчин

Бид ажилтнуудынхаа тав тухтай, бүтээлч сэтгэлгээг нь дэмжсэн, үр бүтээлтэй ажиллах орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн тоногдсон, хамтын ажиллагааг дэмжсэн, нээлттэй төлөвлөлт бүхий ажлын таатай орчныг бүрдүүллээ.

## Ажил амьдралын тэнцвэр

Ажилтнуудынхаа хувийн амьдрал болон карьерын өсөлтийг дэмжих уян хатан цагийн зохицуулалт, цалинтай чөлөөний бодлогыг чухалчлан хэрэгжүүллээ.

- Уян хатан цагийн зохицуулалт: Ажил эхлэх, дуусах цагийг өөрийн амьдралын хэмнэлд тохируулан зохицуулах боломжийг олгодог.
- Цалинтай чөлөөний бодлого: Ар гэрийн гачигдал, эрүүл мэнд болон бусад хувийн чухал асуудлаа шийдвэрлэхэд нь зориулж цалинтай чөлөө олгох замаар ажилтнуудынхаа сэтгэл зүйн амар амгалан байдлыг дэмждэг.



## Байгууллагын соёл ба эерэг уур амьсгал

Бид харилцан хүндлэл, итгэлцэлд суурилсан, бие биеэ дэмжсэн, нэг зорилгын төлөө нэгдсэн залуу, эрч хүчтэй хамт олныг бүрдүүлж, хамтдаа дурсамж бүтээхийг эрхэмлэдэг. Спорт наадам, салбарын баяр, хүүхдийн баяр болон шинэ жилийн баярын арга хэмжээнүүдийг сонирхолтой хэлбэрээр зохион байгуулж, хамт олны идэвх оролцоо, нэгдмэл байдлыг бэхжүүллээ.



Намрын зугаалга

Спорт наадам

Шинэ жилийн арга хэмжээ

## Цалин хөлс, нийгмийн баталгаа

Бид ажилтнууддаа өрсөлдөхүйц цалин хөлс, гүйцэтгэлд суурилсан бодит урамшууллын тогтолцоог хэрэгжүүллээ.



### Урамшуулал

Гүйцэтгэлд суурилсан бодит урамшууллын тогтолцоо



### Дэмжлэг

Өдрийн хоолны мөнгө, хуульд заасан нийгмийн баталгаа болон ажилтанд чиглэсэн төрөл бүрийн хөнгөлөлтүүд

## Шагнал урамшуулал

Манай байгууллага ажилтнуудынхаа амжилт, бүтээмж болон санаачилгыг үнэлж, бодитоор урамшуулах зорилгоор олон талт шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлдэг.

- **Шилдэг ажилтан:** Жил бүр байгууллагын үнэт зүйл, соёл, гүйцэтгэл, манлайллаараа онцгой амжилт гаргасан ажилтныг шалгаруулж, шагнал урамшуулал олгодог бөгөөд 2025 оны шилдэг ажилтан буюу "Rookie of the Year"-ийг шалгаруулан гадаадад аялах эрхээр шагналаа.
- **CECI Awards хөтөлбөр:** Ажилтнуудын идэвх оролцоо, бүтээлч сэтгэлгээ, байгууллагын хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлэх зорилгоор 2025 онд "CECI Awards хөтөлбөр"-ийг амжилттай зохион байгуулж гурван ажилтныг тодруулан урамшуулсан.



# 2025 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

---

# Дижитал шилжилтийн стратеги ба түншлэл

2025 онд “Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь стратеги, бизнесийн хөгжүүлэлт болон технологийн шилжилтийн хүрээнд Монгол улс болон олон улсад тус чиглэлд мэргэшсэн, туршлагатай зөвлөх Арвинд Жошитой амжилттай хамтран ажиллалаа. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд компанийн өнөөгийн бизнесийн загвар, зах зээлийн байр суурь, өрсөлдөх чадварыг нарийвчлан шинжилж, цаашдын дунд болон урт хугацааны хөгжлийн стратегийн чиглэл, хэрэгжүүлэх хувилбаруудыг тодорхойлсон юм.



Зөвлөх үйлчилгээний үр дүнд суурь систем, ERP болон дэвшилтэт дижитал технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэ бизнесийн загварыг боловсруулж, компанийн түвшинд баталсан. Уг бизнесийн загварыг бодитой, үр ашигтай хэрэгжүүлэх зорилгоор стратегийн сонголтуудыг тодорхойлон, түүнд нийцсэн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны процессын загварчлалыг хийж, хэрэгжилтийг үе шаттайгаар эхлүүлээд байна.

Бизнес төлөвлөлтийн хүрээнд Монгол банк, Эдийн засаг, хөгжлийн яам, Монголын Ипотекийн Корпорац зэрэг гол институциудтай уулзалт, хэлэлцээр зохион байгуулж, хамтын ажиллагааны боломж, зохицуулалтын орчин болон үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, урьдчилан тооцоолсон нь стратегийн шийдвэр гаргалтад чухал суурь мэдээлэл болж өгсөн.

Мөн компанийн дотоод болон гадаад оролцогч талуудтай уялдах технологийн экосистемийг бүрдүүлэх хүрээнд нийт 18 технологийн түнш байгууллагатай харилцан ажиллаж, “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-д урт хугацаанд стратегийн үнэ цэн бүтээх боломжтой технологийн платформуудын харьцуулалт, сонголтыг хийж, нэвтрүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Монголын финтек болон холбогдох салбарын компаниудтай стратегийн түншлэл тогтоох зорилгоор “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ийг төлөөлөн зөвлөх үйлчилгээ үзүүлж, хоёр талт уулзалт, хэлэлцээг зохион байгуулсан нь компанийн бизнесийн хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэх бодит боломжуудыг нээсэн онцлох алхам болсон.

Үүнээс гадна Компанийг төлөөлж олон нийтэд нээлттэй, идэвхтэй ажиллан, Дэлхийн банкнаас санаачлан зохион байгуулдаг “Дэлхийн мөнгөний 7 хоног” хөтөлбөрт санхүүгийн боловсрол олгох лекц, зөвлөгөө өгч, нийгмийн хариуцлагын хүрээнд үнэтэй хувь нэмэр оруулсан. Мөн Bloomberg TV-ийн нэвтрүүлэгт оролцож, Монголын санхүүгийн зах зээл, тэр дундаа ББСБ-ын салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар байр сууриа илэрхийлсэн юм.

Дээрх ажлуудын хүрээнд “Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь олон улсын 4 технологийн байгууллага болон дотоодын 14 байгууллагатай уулзалт, хэлэлцээ зохион байгуулж, стратегийн түншлэлийн урт хугацааны суурийг амжилттай тавьсан нь компанийн тогтвортой өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой онцлох үйл явдал болсон.

## Дэлхийн мөнгөний 7 хоног аян

Монгол банктай хамтран “Дэлхийн Мөнгөний 7 хоног - 2025” аяныг "Санхүүгийн зөв шийдвэр, маргаашийн амжилтын эхлэл" уриан дор манай Боловсрол бидний ирээдүй хөтөлбөрт хамтран ажилладаг 15 сургуулийн 30 гаруй сурагчдыг хамруулан зохион байгуулж, хүүхэд залуучуудыг мөнгөө зөв удирдах, хуримтлал үүсгэх, цахим залилангаас сэргийлэх хүрээнд "Интернэт залилангаас өөрийгөө хамгаалах тухай" сэдвээр санхүүгийн ерөнхий мэдлэг түгээн оролцож, мөн Монгол улсын мөнгөн тэмдэгтийн музейтэй танилцлаа.



*Интернэт залилангаас өөрийгөө хамгаалах мэдлэг олгох лекц*

## Цахим сувгууд нэмэгдлээ

Хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, хэрэглэгчдэдээ онлайнаар түргэн шуурхай зээлийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Zeelme, Mcredit, BurenScore зэрэг цахим платформуудтай хамтын ажиллагаагаа эхлүүлж, цахим сувгуудаа нэмлээ.

## Бизнесээ томруулья чуулган

Жижиг дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч нарт зориулсан “Бизнесээ Томруулья” чуулганд бид хавар, намрын улиралд 2 удаа оролцсон бөгөөд эхний чуулганаар харилцагч, бизнес эрхлэгч нартаа уян хатан санхүүгийн боломжуудыг нээх, Empowered by CECI хөтөлбөрт бүртгүүлэх боломжуудыг олгосон бол хоёр дох чуулганаар бизнес эрхлэгч, харилцагч нартаа хэрхэн Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлэн ногоон зээл авах боломжтой талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүргэсэн. Мөн Гүйцэтгэх захирал Б.Азжаргал чуулганы тайзан дээр бизнес эрхлэгчдэд эх үүсвэр амжилттай татсан туршлагаа хуваалцлаа.

Манай зохион байгуулсан социал уралдаанд оролцон “Бизнесээ Томруулья чуулган”-ы тасалбараар шагнуулсан харилцагч тус арга хэмжээний үеэр 25 сая төгрөгийн үнэлгээ бүхий бизнес дэмжлэг авах эрхийн эзэн болсон баяртай үйл явдал тохиосон бөгөөд бид цаашид ч бизнес эрхлэгчдэд боломж олгох олон төсөл хөтөлбөрүүдийг ийнхүү дэмжин ажиллах болно.



## WeCode амлалтад нэгдлээ

“Си И Си Инвестмент ББСБ” нь Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүжилтийн тухай код-WE Finance Code”-д нэгдэж, эмэгтэй бизнес эрхлэгчдэд зээл олгох, эмэгтэйчүүдийн хөрөнгө оруулалт хийх, түүнээс өгөөж хүртэхэд уриалах, зөвлөх, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн дутагдал, хязгаарлалтыг арилгахад туслах арга хэмжээ авч ажиллах тухай амлалт өглөө. Мөн тус ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнесүүдийн санхүүжилтийн түвшинг хэмжих зорилгоор тохиролцсон шалгуур үзүүлэлтүүдийг хэмжин, мэдээлэл нэгтгэгчид тайлагнаж байна.

# СЕЦИ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

“Си И Си Ая Ассет Ван ТЗК” ХХК нь 2025 оны 10-р сарын 20-ны өдөр 3.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй “СЕЦИ ХБҮЦ 1” хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээл дээрээс амжилттай татан төвлөрүүлсэн. Энэхүү үнэт цаасны санхүүжилтээр бид байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцэх ногоон зээл болон бизнесийн зээлийг түлхүү олгох зорилготой ажилласан бөгөөд 2025 оны 4-р улиралд ₮295 саяын ногоон зээл олгосон байна. Цаашид бид үргэлжлүүлэн ногоон бизнес болон санхүүжүүлэлтийг дэмжин ажиллах болно.



“Си И Си Ассет Ван ТЗК” ХХК

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН  
ҮНЭТ ЦААС

UBX Ulaanbaatar  
Securities Exchange

## ТОС Холбоонд элслээ

Санхүүгийн салбарт тогтвортой хөгжил, “Ухаалаг хөрөнгө оруулалтыг дэмжих” зорилгоор, мөн харилцагчдын ногоон хэрэглээ, хөрөнгө оруулалтын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулахаар ТоС холбоонд үндсэн гишүүнээр элслээ. Ийнхүү бид байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх зэргээр салбарын тогтвортой хөгжлийн шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэхийг зорин ажилласан.

Бид зах зээлд ногоон бизнесийн зээл, ногоон хэрэглээний бүтээгдэхүүн худалдан авах зээл, ногоон автомашин худалдан авах зээл, ногоон орон сууц худалдан авах зээл зэрэг ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийг гаргасан бөгөөд харилцагчдад уян хатан зээлийн нөхцөлтэйгээр санал болгож байна.


# ISO/IEC 27001 нэвтрүүлээ

Мэдээллийн аюулгүй байдлын MNS ISO/IEC 27001:2023 Олон Улсын Стандартыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлсэн бөгөөд энэ нь харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, кибер халдлага, бусад тохиолдож болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой билээ. Ийнхүү харилцагчид “Си И Си Инвестмент ББСБ” ХХК-аас илүү найдвартай, итгэл төгс үйлчилгээг хүлээн авах боломжтой боллоо.



# Нийт хөрөнгөө нэмэгдүүллээ

2025 оны нийт хөрөнгийн дүн өмнөх онтой харьцуулахад 2.1 дахин нэмэгдлээ.



# 2025 ОНЫ ОНЦЛОХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



## БОЛОВСРОЛ **БИДНИЙ ИРЭЭДҮЙ** ХӨТӨЛБӨР

Улсын болон хувийн сургууль, цэцэрлэгийн боловсролын чанар болон хүртээмжийн ялгааны тухай асуудал хөндөгдөх болж, эцэг эхчүүд аль болох чанартай, олон талт боловсролыг хүүхдүүддээ эзэмшүүлэх эрмэлзэлтэй буюу залуу үе тасралтгүй суралцах хэрэгцээ шаардлагатай байгаа хэдий ч, сайн боловсролыг эзэмшүүлэхэд төлбөрийн уян хатан нөхцөл хангалтгүй байдал нь томоохон бэрхшээл болж байна.

Иймд Бидний ирээдүй болсон хүүхдүүдэд чанартай боловсролыг эзэмшүүлэхэд тулгарч буй санхүүгийн асуудлыг шийдвэрлэхээр “Боловсрол бидний ирээдүй” сургалтын төлбөрийг хөнгөлөлттэй санхүүжилт буюу хүүхдийн амжилтыг дэмжих, сургууль багш ажилтнуудад хөнгөлөлттэй зээлийг санал болгох цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж, 25 сургуулийг хөтөлбөртөө нэгтгээд байна.



### Хөнгөлөлттэй сургалтын төлбөрийн зээл

Эцэг эхчүүд хүүхдийнхээ сургалтын төлбөрийг урьдчилгаагүй, шимтгэл багатай нөхцлөөр нэг жилийн турш 12 хуваан төлөх нөхцлийг бүрдүүлсэн

### Амжилтыг урамшуулж, сурагчдын идэвхийг дэмжих

Сурлага болон спортын амжилтаараа тэргүүлсэн сурагч 500.0-600.0 мянган төгрөгийн буцаан олголт авах боломжтой

### Хичээлээс гадуур хөгжлийн хөтөлбөр

Хичээлээс гадуур сургалт болон хөгжлийн хөтөлбөрт хамрагдах эрхийг хөтөлбөрт оролцогчдод санал болгодог.



# EMPOWERED BY CECI

## Жижиг дунд үйлдвэрийн өсөлтийг дэмжих хөтөлбөр

Ирээдүйн зорилгоо тодорхойлсон, бизнесээ өргөжүүлэх чин хүсэлтэй, боломж шийдэл эрэлхийлж буй жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Санхүүгийн менежментийн үнэ төлбөргүй зөвлөгөө, Уян хатан санхүүжилтийн боломжийг нэгтгэсэн “Empowered by CECI” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж эхэллээ.

EMPOWERED BY:



Жижиг дунд  
бизнесийн

## ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ

ХӨНГӨЛӨЛТЭЙ САНХҮҮЖИЛТ

“Empowered by CECI” хөтөлбөрийн гол зорилго нь Жижиг дунд бизнес эрхлэгч бизнесийн өсөлт хийхэд туршлага дутмаг бол санхүүгийн удирдлагын зөвлөгөө, консалтинг үзүүлж зорилгодоо хүрэхэд дэмжлэг үзүүлэх юм. Энэ хүрээнд бизнес эрхлэгчдээс нийт 70 орчим хүсэлт ирж, үүнээс 10 бизнес эрхлэгчдийг сонгон урьж, тэдэнд зориулан санхүүгийн удирдлагын практик мэдлэг олгох сургалт, уулзалтыг зохион байгуулав.

Жижиг дунд бизнесийн өсөлтийг дэмжих зорилгын хүрээнд Монголын хамгийн том ЖДБ эрхлэгчдийн чуулган “Бизнесээ томруулья - 1”, “Бизнесээ томруулья - 2” арга хэмжээнд уригдан оролцож, уян хатан санхүүжилтийн боломжит шийдэл, санхүүгийн удирдлагын зөвлөгөөг 50 орчим бизнес эрхлэгчдэд хүргэж амжилттай оролцов.

Зуслан болон хотын захын айл өрхүүдийн чанартай, баталгаатай махны хэрэгцээг хангах зорилготой үйл ажиллагаа эрхэлж буй “Fresh House” компанийн “Бэлх хаус” төсөл нь “Empowered by CECI” хөтөлбөрийн эцсийн шатанд амжилттай шалгарч, эхний 6 сар 1.5% хүүтэй уян хатан Бизнесийн зээлийн санхүүжилт авсан бөгөөд үнэ төлбөргүй санхүүгийн зөвлөх үйлчилгээнд хамрагдаж, шаардлагатай зөвлөгөө мэдээллээ амжилттай авлаа.

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

---

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО


Си И Си Инвестмент нь 2025 оны 10 дугаар сараас эхлэн Тогтвортой санхүүжилтийн (ТоС) холбооны үндсэн гишүүнээр нэгдэж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болголоо. Бид дунд хугацааны стратегийн хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) сайн жишгийг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ нэвтрүүлж, хариуцлагатай ухаалаг санхүүжүүлэгчээр харилцагчидтай хамтран ажиллаж байна.

Энэхүү бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, бүтээгдэхүүн, үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зарчмуудыг удирдлага болгон ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд:

- Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн ногоон зээлд хөнгөлөлттэй, уян хатан нөхцөлийг санал болгож эхэлсэн.
- Чанартай боловсрол, хүйсийн тэгш байдал, санхүүгийн хүртээмжийн зарчимд нийцсэн “Боловсрол бидний ирээдүй” сургалтын төлбөрийн зээлийн үйлчилгээ, жижиг дунд бизнесийн өсөлтийг дэмжсэн - Empowered by CECI хөтөлбөр зэргийг хэрэгжүүллээ.
- Дотоод үйл ажиллагаандаа цахилгааны хэмнэлттэй, цаас, нэг удаагийн хэрэглээг багасгах “Ногоон оффис” шилжилтийг амжилттайгаар эхлүүлээд байна.

## Тогтвортой хөгжилд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалт

Зах зээлд ногоон хэрэглээний бүтээгдэхүүн худалдан авах зээл, ногоон бизнесийн зээл, ногоон орон сууц худалдан авах зээл, ногоон автомашин худалдан авах зээлийг тус тус уян хатан, бага хүүгийн нөхцөлтэйгөөр санал болгон гаргалаа.



# ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ

Одоогийн байдлаар тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцэх нийт 4.2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байна. Үүнд, ногоон зээлээс гадна хосолсон хөдөлгүүрт автомашины зээл, боловсролын зээл, эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон зээл тус тус багтаж байна.

## Бидний нийгэмд үзүүлсэн эерэг нөлөө

Автомашины зээл  
/hybrid/

**₮3.0 тэрбум**

Ногоон зээл

**₮295 сая**

Эмэгтэй бизнес  
эрхлэгчдэд  
олгосон зээл

**₮620 сая**

Боловсролын  
зээл

**₮291 сая**

## НӨЛӨӨ

Си И Си Инвестмент нь “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи”-ийн хүрээнд харилцагчдад санхүүгийн уян хатан шийдэл санал болгохоос гадна, байгальд ээлтэй амьдралын хэв маяг бүрдүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлж, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжин ажиллаж байна.



**УХААЛАГ САНХҮҮЖИЛТ**  
*ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙ*

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

---

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

“Си И Си Инвестмент” ХХК-ийн эрсдэлийн удирдлагын зорилго нь компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн төрөл тус бүрийг системтэйгээр тодорхойлох, үнэлэх, ангилах, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах, шаардлагатай тохиолдолд хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд удирдах замаар байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, ашигт ажиллагаа, нэр хүнд, тасралтгүй, өсөлттэй үйл ажиллагааг хангахад оршино.

Компанийн зүгээс эрсдэлийн удирдлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн “Гурван шугамын загвар”-д тулгуурлан эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгон үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг зарчмын хүрээнд шугам тус бүр нь эрсдэлийг удирдах, хянах, баталгаажуулах чиг үүргийг тодорхой хуваарилалттайгаар хэрэгжүүлдэг. Үүнд:

## I шугам

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж, үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг анхан шатанд тодорхойлох, үнэлэх, удирдах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх үндсэн үүргийг гүйцэтгэдэг.

## II шугам

Эрсдэлийн удирдлага болон нийцлийн чиг үүргийг хэрэгжүүлж, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх аргачлал, бодлогыг боловсруулан хэрэгжилтийг хянах, нэгжүүдэд зөвлөмж, чиглэл өгөх үүргийг хэрэгжүүлдэг.

## III шугам

Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг хараат бус байдлаар үнэлж, удирдлагад баталгаажуулалт болон сайжруулах зөвлөмж өгдөг.

ББСБ-ын эрсдэлийн засаглалын бүрэлдэхүүн хэсгүүд:

1. Хамгаалалтын гурван шугам: Эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа
2. Засаглалын бичиг баримтууд: Эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох эрсдэл, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах журам, стандарт
3. Засаглалын хороод: Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих хороод буюу эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын тавьсан хязгаар үзүүлэлтүүд, бизнесийн болон стратегийн зорилтын хүрээнд хүлээж болзошгүй эрсдэл, тэдгээрийг удирдах хэм хэмжээнд тулгуурлан ялгаатай тогтоож, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнан ажиллаж байна.

## Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлдэгч гэрээний дагуу хүлээсэн төлбөрийн үүргээ бүрэн болон хугацаанд нь биелүүлэхгүй байх, үүнээс үүдэн байгууллагад санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл юм.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Зээлийн эрсдэлийг удирдахдаа зээлийн бодлого, холбогдох журам, зээлдэгчийн скорингийн систем, санхүүгийн шинжилгээ, барьцаа хөрөнгө болон баталгааны механизм, урьдчилсан болон дараах хяналтын тогтолцоог хэрэгжүүлдэг. Мөн зээлийн багцын чанарыг тогтмол үнэлж, шаардлагатай хэмжээний зээлийн эрсдэлийн санг бүрдүүлэн, болзошгүй алдагдлыг санхүүгийн хувьд урьдчилан бэлтгэх зарчмыг баримталж ажилладаг.

Компанийн зүгээс зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор харилцагчдад зээлийн нөхцөл, хүү, шимтгэл, эргэн төлөлтийн хуваарийг бүрэн ойлгуулж, өр орлогын зохистой харьцааг хадгалах, төлбөрийн сахилга баттай байх, санхүүгийн нөөц бүрдүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл хүргүүлэн ажилладаг. Мөн санхүүгийн хүндрэл үүсэх нөхцөлд урьдчилан мэдэгдэж, хамтран шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх замаар зээлийн чанарыг хамгаалах бодлого баримталж байна.

### Үйл ажиллагааны эрсдэл

Дотоод процесс, хүний нөөц, мэдээллийн системийн доголдол, хангалтгүй байдал болон гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан байгууллагад алдагдал үүсэх эрсдэл юм.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Компанийн дотоод процесс, хүний нөөц, мэдээллийн систем, гадаад хүчин зүйлээс үүдэн гарах үйл ажиллагааны эрсдэлийг RCSA (Risk and Control Self-Assessment)-д суурилсан үнэлгээний аргачлалаар тодорхойлж, эрсдэлийн зураглал гарган, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн ажилладаг.

### Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмж алдагдах, мэдээллийн системд зөвшөөрөлгүй нэвтрэх, халдлага үйлдэх зэргээс үүдэн байгууллагад хохирол учрах эрсдэл.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Компанийн мэдээллийн хөрөнгийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах зорилгоор ISO/IEC 27001:2023 стандартын шаардлагад нийцсэн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог (МАБ) нэвтрүүлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд мэдээллийн ангилал, хандалтын удирдлага, осол зөрчлийн удирдлага, тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлдэг.

МАБ-ын эрсдэлийн удирдлагыг эрсдэл хариуцагч эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах арга хэмжээ төлөвлөхөөс эхлүүлж, эрсдэлийн удирдлагын нэгж нэгтгэн хяналт тавих, хэрэгжилтийг баталгаажуулах, эрсдэлийн бүртгэл хөтлөх, үлдэгдэл эрсдэлийг дахин үнэлэх үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

### Санхүүгийн эрсдэл

Компанийн үйл ажиллагаанд СЗХ-ноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган биелүүлэхэд онцгой анхаарч, санхүүгийн үзүүлэлтүүдэд тогтмол хяналт тавьж, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Зохистой үзүүлэлт	Байвал зохих	2025 оны тайлангаар
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	97.40%
Өөрийн хөрөнгө, нийт актив харьцаа	30%-аас доошгүй	61.50%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	42.50%
Өрийн бичгийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	12.80%

## **Зах зээлийн эрсдэл**

Хүүгийн түвшин, валютын ханш, инфляц болон зах зээлийн үнийн хэлбэлзэл зэрэг макро эдийн засгийн хүчин зүйлсийн өөрчлөлтөөс шалтгаалан компанийн санхүүгийн үзүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл хамаарна.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Актив, пассивын удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, эх үүсвэрийн бүтэц, хугацааны зохицуулалтыг оновчтой тодорхойлох, багцын төрөлжилтийг хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

## **Комплайнсын эрсдэл**

Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага, дотоод бодлого, журам болон ёс зүйн стандартыг зөрчсөнөөс үүдэн торгууль, хариуцлага хүлээх, тусгай зөвшөөрөлд сөргөөр нөлөөлөх, нэр хүндэд хохирол учрах эрсдэлийг хэлнэ. Үүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэл хамаарна.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, харилцагчаа таньж баталгаажуулах /KYC/ шалгалт, шаардлагатай тохиолдолд харилцагчаа таньж мэдэх өргөтгөсөн судалгааг хийж, ажилтны сургалт болон зохицуулагчийн шаардлагад нийцсэн тайлагналын тогтолцоог хэрэгжүүлж ажилладаг.

## **Нэр хүндийн эрсдэл**

Олон нийтийн сөрөг ойлголт, мэдээлэл, үйл явдлын нөлөөгөөр байгууллагын нэр хүнд буурч, улмаар харилцагч, орлогын хэмжээнд сөргөөр нөлөөлөх эрсдэл.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Дотоод нууц хадгалах гэрээ, мэдээллийн ил тод байдал, харилцагчийн гомдол шийдвэрлэлтийн механизм, олон нийттэй харилцах бодлого болон сошиал орчны хяналтаар нэр хүндийн эрсдэлийг хамгаалж ажилладаг.

## **Стратегийн эрсдэл**

Бизнесийн зорилго, стратеги буруу тодорхойлогдох, хэрэгжилт хангалтгүй байх, эсхүл гадаад орчны өөрчлөлтөд дасан зохицож чадахгүйгээс шалтгаалан боломж алдах, үр ашиг буурах эрсдэл.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Бизнес болон стратегийн төлөвлөгөөг зах зээл, хууль эрх зүйн өөрчлөлтөд нийцүүлэн тогтмол шинэчилж, SWOT шинжилгээ, KPI гүйцэтгэлийн хяналтад суурилан стратегийн эрсдэлийг удирддаг.

## **Хөрвөх чадварын эрсдэл**

Байгууллага богино хугацааны төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлэх хангалттай мөнгөн хөрөнгө, эх үүсвэргүй болох, эсхүл өндөр зардлаар санхүүжилт татах шаардлага үүсэх эрсдэл.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт: Хөрвөх чадварын харьцааг тогтмол хянаж, мөнгөн урсгалын төлөвлөлт, эх үүсвэрийн төрөлжилт болон шаардлагатай нөөц бүрдүүлэлтээр хөрвөх чадварын эрсдэлийг удирдаж ажилладаг.


# ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

---


# ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Байгууллагын үйл ажиллагааны чухал чиглэлүүдийн нэг нь харилцагчид чиглэсэн чанартай, шуурхай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх явдал юм. Тайлант хугацаанд манай байгууллага харилцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулахад анхааран, харилцагчийн үйлчилгээний стандартаа батлан ажиллаа.

## Харилцагчдын тоо



## Харилцагчдын нас, хүйс



Энэ хүрээнд харилцагчийн үйлчилгээний үйл явцыг оновчтой болгох, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчийн санал хүсэлт, гомдлыг шуурхай шийдвэрлэх чиглэлээр дижитал шийдлүүдийг ашиглах зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Мөн харилцагчдын сэтгэл ханамж, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг хагас жилд 1 удаа зохион байгуулж, судалгаанд үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулах бодлого баримтлан ажиллаж байна.

Цаашид харилцагч төвтэй үйл ажиллагааг бэхжүүлж, үйлчилгээний чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх замаар харилцагчдын итгэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд улам бүр анхааран ажиллана.



# Харилцагчийн үйлчилгээний стандарт

Тайлант онд харилцагчдад найдвартай, хүртээмжтэй, эелдэг, мэргэжлийн түвшний үйлчилгээг үзүүлэхэд чиглэн, харилцагч болон байгууллага хоорондын харилцан итгэлцлийг бий болгох, урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааг дэмжих зорилгоор “Харилцагчийн үйлчилгээ”-ний стандартыг тогтоон баталж, харилцагчийн үйлчилгээний зарчим, ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болон хориглох зарчим, харилцагчдад үйлчилгээ үзүүлэх стандарт, ажлын байранд тавигдах стандарт, сувгуудын харилцааны стандарт, хяналт тавих, дүгнэх, хариуцлага тооцох шаардлагуудыг баримтлан, хэрэгжүүлэн ажиллаа.



## Харилцагчийн үйлчилгээний баримтлах зарчим

Харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй, найдвартай байдлыг хангах

Харилцагчийн оролцоо, хүртээмжийг тэгш хангах

Мэдээлэл зөвлөгөөг үнэн зөв, тодорхой өгч, ил тод байдлыг хангах

Хууль тогтоомж, дотоод дүрэм журмыг ханган ажиллах

Санал гомдлыг хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх, хариу өгөх

Хувийн ашиг сонирхлоо харилцагчийн ашиг сонирхлоос дээгүүр тавихгүй байх

# Шинэ цахим суваг

Си-И-Си Инвестмент нь харилцагчдаа онлайнаар түргэн шуурхай зээлийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Zeelme, Mcredit, BurenScore зэрэг цахим платформуудад нэгдэж, хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн. Энэ нь бид бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрэглэгчдэд улам ойртуулж, хэрэглэгчдийн тоогоо өсгөх эерэг үзүүлэлтүүдийг бий болгосон.


# Дижитал шийдэл

Тайлант онд харилцагчийн үйлчилгээний операторын ачааллыг бууруулах, харилцагчдын дунд хамгийн түгээмэл давтагддаг асуултуудыг автоматжуулах зорилгоор фэйсбүүк чатбот хөгжүүлэлтийг хийсэн бөгөөд энэ нь харилцагчдад 24/7 тасралтгүй үйлчилгээ үзүүлэх, олон хэрэглэгчдэд зэрэг хүрэх боломжийг нэмэгдүүлэх, харилцагчийн туршлагыг сайжруулах олон давуу тал, боломжийг олгож үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлсэн.

CallPro системийг харилцагчийн үйлчилгээний үйл ажиллагаанд ашигласнаар дуудлагын бүртгэл, хяналт, тайлагналын үйл явц сайжирч, харилцагчдад үзүүлэх үйлчилгээний шуурхай байдал нэмэгдсэн. Мөн операторуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, дуудлагын статистик мэдээлэлд үндэслэн үйлчилгээний чанарыг үнэлэх боломж бүрдсэн.

# Биет салбар

Манай салбарууд нь хотын зүүн, төв, баруун хэсэгт тархаж байрладаг бөгөөд тайлант онд нийт биет гурван салбартайгаар үйл ажиллагаа явуулсан.



## Төв оффис



СБД, 1-р хороо, Хотын бизнес төвд, Олимпын гудамж "Нью хоризонс" оффис - 702 тоот

## Түшиг салбар



БЗД 17-р хороо, Да хүрээ, А1-р хаалга Даймонд төв, 2 давхарт, 203 тоот

## Да хүрээ салбар



СБД, 4-р хороо, Сөүлийн гудамж Түшиг төв, 4 давхарт, 403 тоот

## 22 авто худалдааны цогцолбор



СХД, 32-р хороо, 22 авто худалдааны цогцолбор Б блок 2 давхарт, 214 тоот

# Сэтгэл ханамжийн судалгаа

Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг хийсэн бөгөөд харилцагчдын үнэлгээ, санал хүсэлтэд үндэслэн байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах, харилцагч төвтэй үйл ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд харилцагчийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох зорилгоор судалгааг 5 шатлалт шкалаар хэмжсэн буюу “Маш хангалтгүй”, “Хангалтгүй”, “Дунд”, “Сайн”, “Маш сайн” гэсэн үнэлгээний ангиллаар харилцагч сэтгэл ханамжаа илэрхийлэх боломж олгож, үйлчилгээний гүйцэтгэлийг илүү нарийвчлалтайгаар үнэлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Сэтгэл ханамжийн  
дундаж оноо

**3.99**

Ажилтны мэдлэг  
ур чадвар

**4.14**

Харилцагчийн  
итгэлийг хүлээх

**4.07**

Мэдээллийн  
аюулгүй байдал

**4.07**

Мэдээллийн  
хүртээмжтэй байдал

**4.23**

Байгууллагын  
найдвартай байдал

**4.18**

Салбарын тохижилт,  
орчин нөхцөл, тав тух

**3.93**

Салбарын байршил,  
хүрэлцээ

**3.76**

Үйлчилгээний шударга,  
ялгаварлалгүй хандлага

**4.18**

## Санал гомдол, талархал

Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд харилцагчид гомдол, санал шийдвэрлэх хурд, хүртээмж, харилцаанд өгсөн үнэлгээ нь үйлчилгээний өнөөгийн түвшинг тодорхойлох суурь мэдээлэл болж байна. Цаашид санал хүсэлтийг системтэй бүртгэх, дүн шинжилгээ хийх тогтолцоог бүрдүүлэх замаар харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарч ажиллана.

Нийт харилцагчдын 69.7% нь байгууллагыг түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг, 70.6% нь хэрэглэгчдийн санал, гомдлыг шуурхай хүлээн авч, үр дүнтэй шийдвэрлэдэг, 68.1% нь ажилтнуудыг хүнд сурталгүй, эерэг харилцаатай үйлчилдэг гэж үзжээ.

Тайланд хугацаанд харилцагчийн ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч, үүссэн нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлж, цаг алдалгүйгээр 100% шийдвэрлэн ажиллалаа.



# CEC Investment

СИ-И-СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК

---

Бидэнтэй холбогдох:  
Утас: (976) 7575-5511  
Имэйл: [cesi@irc.mn](mailto:cesi@irc.mn)  
Сайт: [www.cesi.mn](http://www.cesi.mn)

---

Хаяг:  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
Олимпийн гудамж, “Нью горизонтс” оффис,  
702 тоот